



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 402

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн
төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 05/11876 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Амарбаясгаланг 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс томилсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ